

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар A/08.

Арвайхээр сум

Г Хээрийн эмнэлэг дэлгэх тухай Г

Гамшигаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 51 дүгээр зүйлийн 51.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1.1, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Заавар батлах тухай" А/303 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшигаас хамгаалах дадлага сургуулитад "Хээрийн эмнэлэг" дэлгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, бэлтгэл ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, зарцуулагдах төсвийн тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангуулан хээрийн эмнэлэг дэлгэж, дадлага сургуулитыг зохион байгуулахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ю.Ичинноров), Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Г.Дашжанцан), Арвайхээр сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт, үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийг байгууллагын гамшигийн эрсдлийг бууруулах төсвөөс зарцуулахыг Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Арвайхээр сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нягтлан бодогч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-т даалгасугай.



Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 15-ны
өдрийн 48 дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт

“ХЭЭРИЙН ЭМНЭЛЭГ” ДЭЛГЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Ю.Ичинноров (Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга)

М.Золзаяа (Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Ц.Рэгзэдмаа (Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн)

Н.Отгонбаяр (Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamжийн хэлтсийн мэргэжилтэн)

Н.Дэжидням (Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamжийн хэлтсийн мэргэжилтэн)

М.Мөнхбаатар (Эрүүл мэндийн газрын эдийн засагч)

Ц.Батжаргал (Эрүүл мэндийн газрын нярав)

Д.Болормаа (Бусийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал)

Д.Наранхүү (Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн аж ахуйн албаны дарга)

Б. Эрдэнэзүл (Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдлийн менежер)

Г.Ганчөдөр (Бусийн оношилгоо эмчилгээний төвийн няглан бодогч)

Г.Надмидсүрэн (Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдвартын сэргийлэлт хяналтын албаны дарга)

Ё.Шүрэнцэцэг (Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвийн дарга)

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 03 сарын 11-ны
өдрийн // дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

“ХЭЭРИЙН ЭМНЭЛЭГ” ДЭЛГЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үйл ажиллагаа | Хариуцах байгууллага | Хамтрах байгууллага | Хугацаа |
|---|---|----------------------------------|---|--------------------------------|
| 1 | Хээрийн эмнэлэг дэлгэх талбай сонгох, эмнэлийн байршилын схем зураг, хаягыг хэвлэх, байршуулах | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Эрүүл мэндийн газар Онцгой байдлын газар | 3-р сарын 15-аас 3 сарын 20 |
| 2 | Эмнэлэг дэлгэхэд шаардлагатай асар, майхан бэлтгэх | Эрүүл мэндийн газар | Онцгой байдлын газар Бусийн оношилгоо эмчилгээний төв | 3-р сарын 14-өөс 3 сарын 20 |
| 3 | Штабын байр, шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэх, ажиллах хүний нөөцийг томилох | Эрүүл мэндийн газар | Онцгой байдлын газар Бусийн оношилгоо эмчилгээний төв | 3-р сарын 14-өөс 3 сарын 22 |
| 4 | 30 ор бүхий хээрийн эмнэлэгт ажиллах 13 тасаг нэгж, шаардлагатай анхан шатны буртгэл маяттыг ОБЕГ-ын даргын 2020 оны А/З03-р тушаалын дагуу бэлтгэх | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Эрүүл мэндийн газар | 3-р сарын 14-өөс 3 сарын 20 |
| 5 | Тасаг нэгжид ажиллах хүний нөөц бурдуулэх, томилж баталгаажуулах | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Эрүүл мэндийн газар | 3-р сарын 14-өөс 3 сарын 22 |
| 6 | Тасаг нэгжид хэрэллэдэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг жагсаалтаар гаргаж, харчуцах зээнг | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, | 3-р сарын 14-өөс 3 сарын 22 |

| | | | | |
|----|--|--|---|----------------------------------|
| | албан тушаал, нэрсээр гаргаж томилон баталгаажуулах, бэлтгэх, байршуулах | | | |
| 7 | Эзэмбэлэн ангилалт хийн 1 цэг байх ба Тухайн Цэлт ажиллах 3 эмч, 3 сувилагч, 2 жолоочийг томилон, шаардлагах асар, майхан, автомашин, узлэгт шаардлагах багаж хэрэсэл, анхан шатны бүртгэл маягтыг бэлтгэх, бэлэн байдлыг хангах | Өрхийн эрүүл мэндийн газар төвүүд | Эрүүл мэндийн газар | 3-р сарын 14-өөс 3 сарын 20 |
| 8 | Хээрийн эмнэлгийн тасаг, нэгжид шаардлагатай цахилгаан үүсгүүрийг бэлтгэх | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Эрүүл мэндийн газар | 3-р сарын 14-өөс 3 сарын 20 |
| | | Өрхийн эрүүл мэндийн төвүүд | | |
| 9 | Хээрийн эмнэлгийн тасаг нэгжид хэрэглэгдэх хангамж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бэлтгэх | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Эрүүл мэндийн газар | 3-р сарын 14-өөс 3 сарын 20 |
| 10 | Хээрийн эмнэлгийн халдвартын тасагт хэрэглэгдэх хувийн хамгаалах хувцас хэрэглэлийг бэлтгэх | Эрүүл мэндийн газар | Бусийн оношилгоо эмчилгээний төв | 3-р сарын 14-өөс 3 сарын 20 |
| 11 | Дасгал сургуулилын үеэр өвчтөн тээвэрлэх, тусламж Үйлчилгээ үзүүлэх тээврийн хэрэгсэл бэлтгэх | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Эрүүл мэндийн газар | 3-р сарын 14-өөс 3 сарын 20 |
| 12 | Шатахуун болон бусад шаардлагатай төсвийг шийдвэрлэх | Эрүүл мэндийн газар Бусийн оношилгоо эмчилгээний төв Өрхийн эрүүл мэндийн төвүүд | - | 3-р сарын 14-өөс 3 сарын 20 |
| 13 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүний хурал зохион байгуулах, бэлтгэл ажлын явцтай танилцах | Эрүүл мэндийн газар | Бусийн оношилгоо эмчилгээний төв Өрхийн эрүүл мэндийн төвүүд | 3-р сарын 20 |
| 14 | Эмнэлгийн тоног төхөөрөмж зөвөрлөх машин техникийг дотоод нөөц боломждоо тулгуурлан бэлтгэх | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Эрүүл мэндийн газар Онцгой байдлын газар | 3-р сарын 20-оос 3-р сарын 22 |

| | | | | |
|----|--|--|--|---|
| 15 | Хээрийн эмнэлгэг дэлгэх талбайд асар майхан барих, тасаг нэгжид тоног төхөөрөмжийг байршуулах, эмнэлгийн үйл ажиллагаа эхлэхэд бэлэн болгох | Эрүүл мэндийн газар | Бусийн оношилгоо эмчилгээний төв Онцгой байдлын газар | 3-р сарын 22 |
| 16 | Эмнэлгийн гадна талбайн тэмдэг тэмдэглээ, хязгаарлалт хийх, гортиг татах | Онцгой байдлын газар, | Эрүүл мэндийн газар Бусийн оношилгоо эмчилгээний төв | 3-р сарын 22 |
| 17 | Эмнэлгийн аюулгүй байдлыг хангах харуул манаа гаргаж, эзлжээр томилон ажиллуулах | Бусийн оношилгоо эмчилгээний төв, | Онцгой байдлын газар, Цагдаагийн газар | 3-р сарын 22-23 |
| | Дадлага байгуулах, дүгнэлт өгөх | Сургуулилтийг зохион ийн эзлжээр томилон ажиллагаанд үнэлгээ | Эрүүл мэндийн газар | Бусийн оношилгоо эмчилгээний төв, Онцгой байдлын газар |

--оо--


 Эрүүл мэндийн газрын даргын
 2023 оны 13 дугаар сарын 15-ны
 өдрийн 18 дугаар тушаалын
 гуравдугаар хавсралт
ИЮН

**ХЭЭРИЙН ЭМНЭЛЭГ ДЭЛГЭХ ДАДЛАГА СУРГУУЛИЛТАД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

| № | Зардлын төрөл | | Хэмжи х нэгж | Тоо хэмжэ э | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Хариуцах байгууллага |
|----|--|---|-----------------|-------------------|----------------------|-------------|----------------------------------|
| 1. | Хээрийн эмнэлгийн байршлын схем зураг | | Ширхэг | 1 /80:12 0/ | 65000 | 65000 | Бүсийн оношилгоо эмчилгээний төв |
| 2. | Тасаг нэгжийн хаяг хэвлүүлэх | | Ширхэг | 15 | 16000 | 240000 | |
| 3. | Шатахуун | | Литр | 100 | 2470 | 247000 | Эрүүл мэндийн газар |
| 4. | Штабын байранд хэрэглэгдэх бичиг хэргийн зардал | | Принтерийн хор | 1 | 60000 | 60000 | |
| | | | Бичгийн цаас | 1 | 25000 | 25000 | |
| | | | Скоч | 2 | 2500 | 5000 | |
| 5. | Шаардлагатай анхан шатны бичиг баримтыг хэвлүүлэх эд шаардлагатай принтерийн хор, цаас | Принтерийн хор | Ширхэг | 1 | 60000 | 60000 | Бүсийн оношилгоо эмчилгээний төв |
| 6. | Цахилгаан үүсгүүр ажиллуулахад шаардлагатай шатахуун | | Бичгийн цаас | Боодол | 1 | 25000 | |
| 7. | Эрэмбэлэн ангилалтын самбар, бугуйвч бэлтгэх | Самбар | Ширхэг | 1 /160:2 40/ | 130000 | 130000 | Өрхийн эрүүл мэндийн төвүүд |
| | | Бугуйвч | Ширхэг | 30 | 2000 | 60000 | |
| | | Шатахуун | Лирт | 60 | 2470 | 148200 | |
| | Нийт | 513500 төгрөг, БОЭТ 337000 төгрөг, ЭМГ Өрхийн ЭМТ-338200 төгрөг, нийт төсөв-1189000 төгрөг | | | | | |